



## НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

---

Улаанбаатар авто зогсоолын менежмент ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** НТАГ-2026/063/НА-СТА-ОНӨҮГ

---

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Улаанбаатар хот  
2026 он

---

**Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Г.Нандинжаргал**  
Утас: 7000-7734 Цахим хаяг: [nandinjargalg@audit.gov.mn](mailto:nandinjargalg@audit.gov.mn)  
**Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер: Х.Түвшинбаяр**  
Утас: 315558 Цахим хаяг: [tuvshinbayarkh@audit.gov.mn](mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn)  
**Аудитын менежер: Д.Отгонбаяр**  
Утас: 325093 Цахим хаяг: [otgonbayarda@audit.gov.mn](mailto:otgonbayarda@audit.gov.mn)  
**Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:**  
**Ари файнэнс аудит ХХК-ийн захирал: Д.Ариунаа**  
Утас: 99088151 Цахим хаяг: [arifin.audit@gmail.com](mailto:arifin.audit@gmail.com)

---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026-05-15 № 710  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

УЛААНБААТАР АВТО ЗОГСООЛЫН  
МЕНЕЖМЕНТ ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ Л.БАТЖАРГАЛ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Улаанбаатар авто зогсоолын менежмент ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудыг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Улаанбаатар хотын хөгжлийн корпораци ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 21 дүгээр "Охин компанийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоол, Улаанбаатар такси каб ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 06 дугаар тогтоолоор Улаанбаатар такси каб ХХК-ийн оноосон нэрийг Улаанбаатар авто зогсоолын менежмент ХХК болгон өөрчилсөн байна.

**Аудитын гол асуудал**

Компани нь толгой компаниас 93.3 сая төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны зардалд зарцуулахаар төлөвлөснөөс 79.7 сая төгрөгийг зарцуулсан байна. Үүнд орон тоо дутуу ажилласан нь гол нөлөө үзүүлсэн байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

### **Бусад асуудлын хэсэг**

Улаанбаатар авто зогсоолын менежмент ХХК нь эрхэм зорилгоо нийслэл Улаанбаатар хотын авто зогсоолын сүлжээг хөгжүүлэх, хөгжлийг тодорхойлогч компани байна гэж тодорхойлж 7 зорилт дэвшүүлсэн байна

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		1 сарын 1	12 сарын 31
1	ХӨРӨНГӨ	0.00	0.00
1.1	Эргэлтийн хөрөнгө	0.00	0.00
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	14,787.96	14,491,823.37
1.1.02	Дансны авлага	0.00	0.00
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	0.00	0.00
1.1.04	Бусад авлага	0.00	0.00
1.1.05	Бусад санхүүгийн хөрөнгө	0.00	0.00
1.1.06	Бараа материал	0.00	500,000.00
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	4,153,000.00	33,853,000.00
1.1.08	Бусад эргэлтийн хөрөнгө	0.00	0.00
1.1.09	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эрг-н бус хөрөнгө	0.00	0.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	4,167,787.96	48,844,823.37
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	0.00	0.00
1.2.01	Үндсэн хөрөнгө	14,384,350.81	14,102,550.81
1.2.02	Биет бус хөрөнгө	0.00	3,960,000.00
1.2.03	Биологийн хөрөнгө	0.00	0.00
1.2.04	Урт хугацаат хөрөнгө оруулалт	0.00	0.00
1.2.05	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	0.00	0.00
1.2.06	Хойшлогдсон татварын хөрөнгө	0.00	0.00
1.2.07	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	0.00	0.00
1.2.08	Бусад эргэлтийн бус хөрөнгө	0.00	0.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	14,384,350.81	18,062,550.81
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>18,552,138.77</b>	<b>66,907,374.18</b>
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	0.00	0.00
2.1	Өр төлбөр	0.00	0.00
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.1.01	Дансны өглөг	45,253,000.00	103,515,689.41
2.1.1.02	Цалингийн өглөг	0.00	0.00
2.1.1.03	Татварын өр	0.00	448,932.31
2.1.1.04	НДШ - ийн өглөг	0.00	0.00
2.1.1.05	Богино хугацаат зээл	0.00	0.00
2.1.1.06	Хүүний өглөг	0.00	0.00
2.1.1.07	Ногдол ашгийн өглөг	0.00	0.00
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	0.00	0.00
2.1.1.09	Нөөц /өр төлбөр/	0.00	0.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.1.11	Борлуулах бүлэг хөрөнгөнд хамаарах өр төлбөр	0.00	0.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	45,253,000.00	103,964,621.72

Улаанбаатар авто зогсоолын менежмент ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн  
аудитын тайлан

2.1.2	Урт хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.2.01	Урт хугацаат зээл	0.00	0.00
2.1.2.02	Нөөц /өр төлбөр/	0.00	0.00
2.1.2.03	Хойшлогдсон татварын өр	0.00	0.00
2.1.2.04	Бусад урт хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	0.00	0.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	45,253,000.00	103,964,621.72
2.3	Эздийн өмч	0.00	0.00
2.3.01	Өмч: - төрийн	100,000.00	100,000.00
2.3.02	- хувийн	0.00	0.00
2.3.03	- хувьцаат	0.00	0.00
2.3.04	Халаасны хувьцаа	0.00	0.00
2.3.05	Нэмж төлөгдсөн капитал	0.00	0.00
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	0.00	0.00
2.3.07	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	0.00	0.00
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	29,990,000.00	29,990,000.00
2.3.09	Хуримтлагдсан ашиг	-56,790,861.23	-67,147,247.54
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	0.00	-25,457,386.31
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	-56,790,861.23	-41,689,861.23
2.3.11	Эздийн өмчийн дүн	-26,700,861.23	-37,057,247.54
2.4	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>18,552,138.77</b>	<b>66,907,374.18</b>

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

Мөрийн дугаар	Балансын зүйл	/төгрөгөөр/	
		Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
01	Борлуулалтын орлого (цэвэр)	0.00	0.00
02	Борлуулалтын өртөг	0.00	0.00
03	Нийт ашиг( алдагдал)	0.00	0.00
04	Түрээсийн орлого	0.00	0.00
05	Хүүний орлого	0.00	6,070.03
06	Ногдол ашгийн орлого	0.00	0.00
07	Эрхийн шимтгэлийн орлого	0.00	0.00
08	Бусад орлого	0.00	0.00
08.1	Орлогын дүн	0.00	6,070.03
09	Борлуулалт, маркетингийн зардал	0.00	0.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	5,958,500.00	25,462,849.34
11	Санхүүгийн зардал	0.00	0.00
12	Бусад зардал	0.00	0.00
12.1	Зардлын дүн	5,958,500.00	25,462,849.34
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.00	0.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	0.00	0.00

Улаанбаатар авто зогсоолын менежмент ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

17	Бусад ашиг ( алдагдал)	0.00	0.00
17.1	Олз, гарзын дүн	0.00	0.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг( алдагдал)	-5,958,500.00	-25,456,779.31
19	Орлогын татварын зардал	0.00	607.00
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-5,958,500.00	-25,457,386.31
21	Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал)	0.00	0.00
22	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)	-5,958,500.00	-25,457,386.31
23	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0.00	0.00
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
23.3	Бусад олз (гарз)	0.00	0.00
24	Орлогын нийт дүн	0.00	0.00
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	0.00	0.00

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
01	2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	100,000.00	29,990,000.00	-56,790,861.23	-26,700,861.23
09	2024 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	100,000.00	29,990,000.00	-56,790,861.23	-26,700,861.23
10	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	15,101,000.00	15,101,000.00
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	-25,457,386.31	-25,457,386.31
17	2025 оны 12 сарын 31-р үлдэгдэл	100,000.00	29,990,000.00	-67,147,247.54	-37,057,247.54

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
0	Мөнгөн хөрөнгөөс мөнгөн хөрөнгө рүү бичсэн гүйлгээ	0.00	0.00
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	8,070.03
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	0.00	0.00
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	0.00	0.00
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	0.00	0.00
1.1.4	Буцаан авсан албан татвар	0.00	0.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	0.00	0.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	0.00	8,070.03

Улаанбаатар авто зогсоолын менежмент ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн  
аудитын тайлан

1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	12,000.00	17,213,722.62
1.2.1	Ажиллагчдад төлсөн	0.00	5,447,702.96
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	0.00	747,079.21
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	0.00	8,188,300.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	0.00	0.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс,сэлбэг хэрэгсэлд төлсөн	0.00	0.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	0.00	0.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	0.00	607.00
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	0.00	0.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	12,000.00	2,830,033.45
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-12,000.00	-17,205,652.59
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	31,682,688.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	31,682,688.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	31,682,688.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-12,000.00	14,477,035.41
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>26,787.96</b>	<b>14,787.96</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>14,787.96</b>	<b>14,491,823.37</b>

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө /тухайн санхүүжилтийн сар/	Гүйцэтгэл /тухайн санхүүжилтийн сар/	Гүйцэтгэл /хувиар/
1	<b>Мөнгөн хөрөнгийн 2026 оны 12-р сарын 1-ний үлдэгдэл</b>	14,787.96	14,787.96	
2	<b>I. ОРЛОГЫН ДҮН</b>	<b>93,282,690.00</b>	<b>93,288,760.00</b>	
5	Толгой компаниас зээлээр санхүүжилт	93,282,690.00	93,282,690.00	
6	Хүүний орлого		6,070.00	
8	<b>II. НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН</b>	<b>93,282,690.00</b>	<b>79,670,532.98</b>	<b>85%</b>
9	<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал</b>	<b>9,019,740.00</b>	<b>6,723,715.56</b>	<b>75%</b>
10	Цалин хөлс	8,017,550.00	5,976,636.35	75%
11	НДШ- (байгууллагаас төлөх 12.5%)	1,002,190.00	747,079.21	75%
13	<b>Харилцаа холбооны зардал</b>	<b>420,000.00</b>	-	<b>0%</b>
14	Утас,Интернет	420,000.00	-	0%
16	<b>Үйл ажиллагааны зардал</b>	<b>49,847,950.00</b>	<b>44,993,242.42</b>	<b>90%</b>
17	Оффис байр	39,600,000.00	9,900,000.00	25%
18	Оффис хангамж	1,551,950.00	592,008.97	38%
20	Мэргэжлийн болон зөвлөх үйлчилгээ	5,000,000.00	2,304,545.45	46%
23	Бусад зардал /гэх мэт/	3,696,000.00	496,688.00	13%
24	Урьдчилж төлсөн тооцоо		29,700,000.00	
25	Аудит		2,000,000.00	

Улаанбаатар авто зогсоолын менежмент ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

29	Үндсэн хөрөнгийн нийт зардал		328,875.00	
30	Элэгдлийн зардал		328,875.00	
31	<b>Хөрөнгө оруулалт</b>	<b>12,315,000.00</b>	<b>7,624,700.00</b>	<b>62%</b>
32	Компьютер, программ хангамж	6,815,000.00	<b>3,664,700.00</b>	<b>54%</b>
33	Санхүүгийн программ	5,500,000.00	<b>3,960,000.00</b>	<b>72%</b>
36	<b>Төлөөлөн удирдах зөвлөл</b>	<b>1,680,000.00</b>	-	<b>0%</b>
39	Хурлын зардал	1,680,000.00	-	<b>0%</b>
40	<b>Өглөг</b>	<b>20,000,000.00</b>	<b>20,000,000.00</b>	
41	ШШГГ-ын шийдвэрээр өр /Бодь цамхаг ХХК/	<b>20,000,000.00</b>	20,000,000.00	
42	Өр төлбөр		528,933.39	
45	<b>Мөнгөн хөрөнгийн 2026 оны 1р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>14,787.96</b>	<b>14,490,823.37</b>	

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой 3,141.0 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

#### Залруулсан алдаа:

- Санхүүгийн тайлан дахь мөнгөн хөрөнгийн эхний, эцсийн үлдэгдэл банкны үлдэгдэлийн баталгаа болон харилцах дансны үлдэгдэл 1.0 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэснийг;
- Санхүүгийн тайлан дахь биет болон биет бус хөрөнгийн дүн үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлийн тайлангийн дүн 3,140.0 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэснийг;

Эдгээр нь НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга 1.27-д “санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой”, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 “иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “*нийцсэн бөгөөд зохистой байх*”, “*үнэн зөв байх*”, “*иж бүрэн байх*”, батламж мэдэгдлийг хангахгүй байгааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэж заасны дагуу залруулга хийлгэж санхүүгийн тайланг баталгаажуулав.

Аудитаар нийт 318.7 мянган төгрөгийн 1 зөрчил<sup>1</sup> илэрч төлбөрийн акт тогтоосон.

Нийт залруулагдаагүй 318.7 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.  
НТАГ-2026/063/НА-СТА-ОНӨҮГ

### **3.1 Төлбөрийн акт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчиж байгууллагын даргын тушаал шийдвэргүйгээр 318.7 мянган төгрөгийн mercı шоколад болон бэлэгний уут худалдан авч шууд зардлаар бүртгэж, төсвийг үрэлгэн зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлангийн "үнэн зөв байх", "иж бүрэн байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Байгууллагын даргын тушаал шийдвэргүйгээр шууд зардлаар бүртгэж олгосон бэлэг дурсгалд зарцуулсан 318.7 мянган төгрөгийг нөхөн төлүүлж, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### 4.1. Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс Залруулсан	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Санхүүгийн тайлан дахь мөнгөн хөрөнгийн эхний, эцсийн үлдэгдэл банкны үлдэгдэлийн баталгаа болон харилцах дансны үлдэгдэл 1.0 мянган төгрөгөөр зөрүүтэй	1	1,000.0			1	1,000.0	1	1,000.0
2	Санхүүгийн тайлан дахь биет болон биет бус хөрөнгийн дүн үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлийн тайлангийн дүн 3,140.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан	1	3,140.0			1	3,140.0	1	3,140.0
	<b>Дүн</b>	<b>2</b>	<b>3,141.0</b>			<b>2</b>	<b>3,141.0</b>	<b>2</b>	<b>3,141.0</b>

##### 4.2. Санхүүгийн тайлангийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчиж байгууллагын даргын тушаал шийдвэргүйгээр 318.7 мянган төгрөгийн mercі шоколад болон бэлэгний уут худалдан авч шууд зардлаар бүртгэж, төсвийг үрэлгэн зарцуулсан	1	318.7	1	318.7				
	<b>Дүн</b>	<b>1</b>	<b>318.7</b>	<b>1</b>	<b>318.7</b>				